



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29. өдөр

Дугаар A/56.

Цагаантолгой

Г Бэлчээрийн харилцааг зохицуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Газрын тухай хууийн 52.2, Тариалангийн тухай хуулийн 24.1.1, 24.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 08 сарын 19 –ний өдрийн 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын тариалалтыг, технологит хугацааг мөрдүүлэн эхлүүлэх, бэлчээрийг хуваарьтай ашиглах харилцааг зохицуулах зорилгоор малчид болон мал бүхий иргэд 2022 оны 05 сарын 01–ний өдрөөс 2022 оны 05 сарын 10 –ны өдрийн хооронд малыг хариуллагатай байлгах, 2022 оны 05 сарын 10 –ны дотор зусландаа гарах, 2022 оны 10 сарын 05 –ны өдрөөс хойш намаржаанд буухаар тус тус тогтоосугай.

2.Тариалангийн талбайг байнгын манаачтай байлгаж, манаачийг унаагаар хангах, цаашид талбайгаа бүрэн хашаажуулахад анхаарч ажиллахыг төмс хүнсний ногоо тариалагчид, тариалан эрхлэгч иргэн, Аж ахуй нэгжийн удирдлагуудад даалгасугай.

3.Малчид мал бүхий иргэдийг тогтоосон хугацаанд зусландаа гарах, зусландаа гарахаас өмнөх хугацаанд мал сүргийг хариулгатай байлгах ажлыг зохион байгуулалтанд оруулж үр тариа, төмс хүнсний ногоо тариалах, хураах боломжийг бүрдүүлж ажиллахыг Ивэн багийн Засаг дарга (Л.Сэлэнгэсайхан), Хушаат багийн Засаг дарга (Б.Золбаяр) нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтийг ханган малчин, мал бүхий иргэд, тариаланч, ногоочид, ААН-үүдэд холбогдох хууль, журмыг танилцуулж, гарын авалга, тараах материалыар ханган, зөвлөмж өгч, мэдэгдэл хүргэж хамтран ажиллахыг холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

5.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (А.Батдорж)-д үүрэг болгосугай.

6.Хамтран ажиллах мэргэжилтнүүдийн нэrsийг хавсралтаар баталсугай.

7.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 09 сарын 29 –ний өдрийн A/111 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

Ашиг

С.ШИЖИРБААТАР

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг даргын  
2022 оны 04 сарын 29-ний өдрийн ..... тоот  
захирамжийн хавсралт

Ивэн баг

- 3.Цолмон - /Хөдөө аж ахуйн тасгийн дарга/
- Б.Батсайхан - / Газрын даамал/
- Б.Наранцэцэг - / Татвар хураагч/
- Г.Ганжолоо - / Ивэн багийн Байгаль хамгаалагч/

Хушаат баг

- Б.Мөнх-Эрдэнэ - / Засаг даргын орлогч/
- А.Батдорж - /Байгаль орчны хяналтын Улсын байцаагч/
- Ч.Төгсбаатар - / Хушаат багийн Байгаль хамгаалагч/
- Ч.Азжаргал - / Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Боловсруулсан: Г. Чолпон  
Хянасан: С. Шагнурдааовч  
Хувь: 2  
Огноо: 2022.04.24.